



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 91

Дархан

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг сурталчлах, орон нутгийн хөгжилд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцох нөхцөлийг хангах арга хэмжээг зохион байгуулах “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн дэд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, үр дүнг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг аймгийн Салбар хороо /Ч.Энхбат/-д даалгасугай.

ДАРГА

Г.ЭРДЭНЭБАТ



ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нийтлэг үндэслэл

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний чуулга уулзалтаар “Эх дэлхийгээ шинэчэлье” уриан дор “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030” баримт бичгийг баталж, тогтвортой хөгжлийн асуудлыг хамруулсан 17 зорилгыг дэвшүүлсний нэг нь Жендэрийн тэгш байдал¹ыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр тусгасан асуудал юм.

Монгол Улсын УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны бодлогын баримт бичгийг батлан нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчимд “...нийгмийн хөгжил, дэвшилд жендэрийн тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчныг бүрдүүлэх”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэж тус тус тусгасан.

Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлан, хүрэх үр дүнд бүх аймагт дэд хөтөлбөр батлагдсан байхаар тодорхойлсон нь энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулах чиглэл болж байна. Мөн аймгийн хэмжээнд иргэдийн болон орон нутгийн хөгжлийг хангахад чиглэгдсэн 15 дэд хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгүүд батлагдан, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ч салбар дундын бодлогыг уялдуулсан жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Жендэрийн дэд хөтөлбөр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн, хүн амын бүлгүүдийн тулгамдсан асуудал, хэрэгцээг судлан бодлого төлөвлөлтөд тусгах, орон нутгийн хөгжилд оролцох нөхцөлийг бүрдүүлэх замаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалтыг чанаржуулах арга зам болох юм.

Нэг. Дэд хөтөлбөр боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага

Дархан-Уул аймаг 101,8 мянган хүн амтай. Үүнээс эрэгтэй 49915, эмэгтэй 51964 аймгийн нийт хүн амын доторх хүйсийн харьцаа 49:51 байна. /2017 оны аймгийн статистик пүнгээр/

Манай аймгийн хувьд 0-79 насны иргэдийн хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй, түүнээс дээш насныхны хувьд эмэгтэй хүйс давамгайлж байна. Энэ нь эрэгтэйчүүдийн нас баралттай холбоотой. Хүн амын дундаж наслалт манай аймгийн хувьд 69, үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 65, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75 байна.

Эрх толгойлсон² хүний тоо 4192, үүнээс эрэгтэй 615, эмэгтэй 3577 /хүйсийн харьцаа 15:85/

Хөдөлмөрийн насны хүн ам 62157, ажилгүй иргэд 3766, үүнээс эрэгтэй 1342, эмэгтэй 2424 /хүйсийн харьцаа нь 36:64/ байна. Нийт ажилгүй иргэдийн ихэнх хувийг

эмэгтэйчүүд эзлэж байгаа нь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа /2017 он/:

Дархан-Уул аймагт төрийн 96 байгууллагад 4545 төрийн албан хаагч, үүнээс эрэгтэй 1437, эмэгтэй 3108 ажилтан ажиллаж байна.

Удирдах албан тушаалд 244 албан хаагч байгаагаас эрэгтэй 99, эмэгтэй 145, /хүйсийн харьцаа 40:60/,

Гүйцэтгэх албан тушаалд 4301 албан хаагч байгаагаас эрэгтэй 1338, эмэгтэй 2963 /хүйсийн харьцаа 31:69/ ,

Улс төрийн албан тушаалд 43 албан хаагч байгаагаас эрэгтэй 25, эмэгтэй 18 /хүйсийн харьцаа 58:42/,

Төрийн захиргааны 27 байгууллагын 60 удирдах албан тушаалд эрэгтэй 28, эмэгтэй 32, /хүйсийн харьцаа 46:54/,

Төрийн тусгай 7 байгууллагын удирдах албан тушаалд 9 албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд эрэгтэй 9, эмэгтэй 0 /хүйсийн харьцаа 0:100/,

Төрийн үйлчилгээний 65 байгууллагын удирдах албан тушаалд 128 албан тушаалтан ажиллаж байгаагаас эрэгтэй 36, эмэгтэй 92 /хүйсийн харьцаа 28:72/ тус тус байна.

Орон нутгийн шийдвэр гаргах түвшний хүйсийн харьцааг тодорхойлох

№	Төлөөлөх газар	2012 оны сонгууль			Хүйсийн харьцаа	2016 оны сонгууль			Хүйсийн харьцаа
		Бүгд	эрэгтэй	эм		Бүгд	эрэгтэй	эм	
1	Аймгийн ИТХ	33	30	3	91:9	33	27	6	82:18
2	Дархан сум	31	29	12	61:39	31	20	11	65:35
3	Шарын гол сум	27	19	8	70:30	27	18	9	67:33
4	Орхон сум	21	11	10	52:48	21	13	8	62:38
5	Хонгор сум	27	11	8	70:30	27	22	5	82:18

2012 оны орон нутгийн сонгуулиар Аймгийн ИТХ-д сонгогдсон 33 төлөөлөгчдийн эрэгтэй 30, эмэгтэй 3 /хүйсийн харьцаа 91:9/ байсан бол 2016 онд сонгогдсон 33 төлөөлөгчдийн эрэгтэй 27, эмэгтэй 6 /хүйсийн харьцаа 82:18/ болсон.

График 1 /2012 оны орон нутгийн сонгуулиар сумын ИТХ-д сонгогдсон төлөөлөгчдийн хүйсийн харьцаа/





График 2 /2016 оны орон нутгийн сонгуулиар сумын ИТХ-д сонгогдсон төлөөлөгчдийн хүйсийн харьцаа/



Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 27 ЕБСургууль байгаагаас 2017-2018 оны хичээлийн жилд суралцаж буй 19715 суралцагчийн эрэгтэй 9948, эмэгтэй 9767 /хүйсийн харьцаа 50:50/.

Их, дээд 6 сургуульд суралцаж байгаа 3771 оюутан суралцагчид, үүнээс эрэгтэй 1683, эмэгтэй 2088 /хүйсийн харьцаа 45:55/, мэргэжлийн анхан шатны болон дунд шатны боловсрол олгох 3 сургуульд 1957, үүнээс эрэгтэй 1340, эмэгтэй 617 /хүйсийн харьцаа 68:32/ суралцагчид байна.

Техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцаж байгаа суралцагчдын хүйсийн харьцааг авч үзэхэд эрэгтэй давамгайлсан, их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудын хүйсийн харьцааг авч үзэхэд эмэгтэй давамгайлсан байна.

Иймд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд зориулсан мэргэжил сонгох, мэргэжил сурталчлах ажлуудыг өргөн хүрээнд зохион байгуулах шаардлагатай.

2016.12.21-нээс 2017.06.30-ныг хүртэлх хугацаанд үйлдэгдсэн бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын байдлыг судлахад нийт 53 хохирогчоос гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон нийт 5 иргэн байгаа бөгөөд бүгд эмэгтэй байна. /2002 онд батлагдсан Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн/

2017.07.01-2017.12.22-ныг хүртэлх хугацаанд үйлдэгдсэн бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын байдлыг судлахад нийт 123 хохирогчоос гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон нийт 33 иргэн, үүнээс эмэгтэй 26, эрэгтэй 7 хохирогч байна. /2015 онд батлагдсан Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн/

Шинэ Эрүүгийн хууль үйлчилж эхэлснээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь дан ганц эмэгтэйчүүд биш эрэгтэйчүүд ч байдаг гэдэг нь судалгаагаар нотлогдож байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн эхнэр, нөхрийн хооронд үйлдэгддэггүй, хамтран амьдрагч, эцэг эх хүүхдийн, ах дүү нарын дунд ч үйлдэгддэг байна.


Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн дээрх судалгаанууд нь зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн талаар байх бөгөөд энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэлийн нийт хэрэг, зөрчлийн талаар дүгнэлт гаргахад хангалтгүй юм.

Учир нь жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн хүчирхийллээс гадна ажлын байрны бэлгийн дарамт, хүн худалдаалах, хүчиндэх зэрэг олон хэлбэртэй бөгөөд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн хууль зэрэг эрх зүйн олон хэм хэмжээгээр зохицуулагдаж байдаг.

Иймээс хуулийн байгууллагын ажилтнуудад жендэрт суурилсан хүчирхийллийн талаар мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг хийх нь бодит нөхцөл байдлыг тодруулахад чухал үр нөлөөтэй.

Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд хийгдсэн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх үндэсний хэмжээний судалгаа²наас харахад.


Хамтрагчийн зүгээс бие махбодын болон /эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар, 2017 он / хамтрагчтай байсан/ байгаа эмэгтэйчүүдийн тоо/



²Хүчирхийллийн нүцгэн үнэн 2018 /Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017/

Дээрх графикаас харахад хамтрагчийн үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Дархан-Уул аймагт (41.0%) хамгийн өндөр байна

Мөн бусдын зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэл, хугацаагаар 2017 он / судалгаанд хамрагдсан 15-64 насны эмэгтэйчүүдийн тоо/ үзвэл:



Дээрх графикаас үзвэл бусдын зүгээс хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Дархан-Уул аймагт 20,8 /амьдралдаа/ байгаа нь улсын дунджаас 3,5%-иар илүү байна.

Иймд иргэдийн хүчирхийллийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд заавал хуулийн байгууллагад хандаж байх талаар мэдээлэл, танилцуулгыг байнга хүргэх шаардлагатай байна.

Дархан-Уул аймагт жендэрийн тэгш байдлыг хангахад тулгамдаж буй асуудлуудыг иргэдээс асуулга судалгаа авахад: /487 хүн/

- ✓ Ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тэгш бус байдал /Цалин хөлс урамшууллын үнэлгээ, ажилд орох, ажлаас халагдах явцад, тэтгэвэр тэтгэмж тогтоолгох, амралт эдлэхэд, албан тушаал ахих, ажил мэргэжлээ дээшлүүлэх г.м/ 26,4% /129/

- ✓ Гэр бүлийн харилцаатай холбоотой тэгш бус байдал /хүүхэд, өндөр настан, ХБИ асрах, халамжлах, хүмүүжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх байдал г.м/ 20,1% /98/
- ✓ Улс төрийн оролцоо, шийдвэр гаргах түвшинтэй холбоотой тэгш бус байдал /удирдах албан тушаалд томилогдох, нэр дэвших, сонгогдох, шийдвэр гаргах түвшин дэх эрэгтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь г.м/ 17,2% /84/
- ✓ Эрүүл аж төрөх байдал, эрүүл мэндийн үзүүлэлт, үйлчилгээний тэгш бус байдал /төрөлт нас баралт, эрэгтэй эмэгтэйчүүдийн өвчлөлийн байдал, үзлэг оношилгоонд хамрагдалт, эрүүл аж төрөх хэв маяг, дасгал хөдөлгөөн г.м/ 15,1% /74/
- ✓ Өрхийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэл, хувиараа бизнес эрхлэхтэй холбоотой тэгш бус байдал /эрэгтэй эмэгтэйчүүдийн орлого, өмчлөл, барьцаа хөрөнгө, зээл, хөрөнгө оруулалт г.м/ 11,7% /57/
- ✓ Боловсрол эзэмших, боловсролын хүртээмжийн тэгш бус байдал /Сурагчид, оюутнуудын элсэлт, төгсөлт, мэргэжлээ сонгох, авьяас ур чадваараа хөгжүүлэхэд нөлөөлөх хандлага г.м/ 9,2% /45/



Дээрх үзүүлэлтүүдээс харахад Жендэрийн мэдрэмж³-тэй бодлогыг салбар дундын уялдаатайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд

- Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн салбар хорооны чадавхийг бэхжүүлэх,
- Орон нутагт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах,
- Төсөл хөтөлбөрт хамрагдах, аливаа үйл ажиллагаанд оролцох иргэдийн хүйсийн тэнцвэрт байдлыг хангах,
- Нас баралтын зонхилох шалтгаан, нөхцөлийн талаар суурь судалгаа хийж, шалтгааныг багасгахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах,
- Гэр бүлийн харилцаанд эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх,
- Гэр бүл салалт хүүхдийн тэтгэлэг тогтоолт, хүүхэд үрчлэлт, хараа хяналтгүй хүүхдийн хамгаалалт, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг хариуцлага зэрэгт хяналт тавих,
- Орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Их, дээд сургууль, коллежид суралцагсдын хүйсийн ялгаатай байдлыг арилгахад чиглэсэн нөлөөллийн ажлыг нэмэгдүүлэх зэрэг салбар дундын уялдаа холбоог сайжруулах,

᠑Жендэрийн мэдрэмж гэж эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимээс нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар юм.

- Сургалтын хэрэглэгдэхүүнд буй зураг, үзүүлэн нь хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалсан байхад анхаарч боловсруулах,
- Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд аав нарын оролцоог тодорхой хувиар нэмэгдүүлэх зэргээр орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан энэхүү дэд хөтөлбөрийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, холбогдох салбаруудын дэд хөтөлбөрүүдтэй уялдуулан боловсрууллаа.

Хууль эрх зүйн үндэслэл

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоол;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Холбогдох бусад эрх зүйн актууд;

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг хангах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт:

- 3.1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх
- 3.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх
- 3.3. Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах
- 3.4. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг аймаг, сум, багийн түвшинд хэрэгжүүлэх
- 3.5. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Дөрөв. Хөтөлбөрийн хугацаа

Дэд хөтөлбөрийг 2019-2021 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1. Нэгдүгээр үе шат: 2019 онд орон нутгийн чадавхи бүрдүүлэх, жендэрийн талаарх сургалт, сурталчилгаа, жендэрийн мэдрэмжтэй нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулна.

4.2. Хоёрдугаар үе шат: 2020-2021 онд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, сайжруулах шаардлагатай үйл ажиллагаанд арга хэмжээг авч, цаашид хэрэгжүүлэх жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах.

Тав. Хамтран хэрэгжүүлэх байгууллагууд

1. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
2. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар
3. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд
4. Хууль хяналтын байгууллага
5. Аж ахуй нэгжүүд
6. Төрийн бус байгууллага
7. Боловсролын сургалтын байгууллагууд

Зургаа. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх

6.1.1 Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм соёл, эдийн засаг, гэр бүлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийж, холбогдох байгууллагуудад танилцуулан үйл ажиллагаанд тусгах арга хэмжээ авах;

6.1.2 Төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгахад нөлөөлөх;

6.1.3 Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах;

6.1.4 Аймгийн хэмжээний жендэрийн статистикийн хүйсээр ангилсан мэдээллийн тоо, чанарыг дээшлүүлэх.

6.2 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх

6.2.1 Аймгийн жендэрийн салбар хороог чадавхижуулах;

6.2.2 Сумын Засаг дарга, хэлтэс, агентлагийн дарга нартай хийх үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах асуудлыг тусгах;

6.2.3 Төр, хувийн хэвшил, ИНБ-ын түншлэлийн хүрээнд аймагт жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар үйл ажиллагаа явуулах;

6.2.4 Удирдах ажилтнууд, манлайлагчдыг жендэрийн сургалтанд хамруулах;

6.2.5 Төрийн албан хаагчдыг жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалтанд хамруулах, сургагч багш бэлтгэх;

6.2.6 Аж ахуйн нэгж байгууллагуудад жендэрийн эрх тэгш байдлыг сурталчлах, хялбаршуулсан сурталчилгааны материал, гарын авлага, зөвлөмжийг гаргах;

6.2.7 Орон нутгийн мэргэшсэн ТББ-аар аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх;

6.2.8 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн асуудлаар олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;

6.2.9 Аймаг, сумдаас ИТХ-д сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдийн манлайллыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах.

6.3 Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах

6.3.1 Гэр бүлийн гишүүдэд жендэрийн эрх тэгш байдлын талаар мэдээлэл хүргэх, эцэг эхийн хамтын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийг багаас нь амьдрах ухаанд сургах;

6.3.2 Нөхөн үржихүйн эрүүл мэндэд эрчүүд, эмэгтэйчүүдийн хүлээх үүрэг хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

6.3.3 Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнээс орхигдож болзошгүй хүн ам, зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд үзүүлэх "ГАРЦ" арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

6.4.4 Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

6.4.5 Бүх нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш хамруулах, спортоор дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах;

6.4.6 ЕБ-ын 9-12-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах;

6.4.7 Ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдлыг анхаарсан жендэрийн мэдрэмжтэй байгууллагын соёлыг төлөвшүүлсэн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах;

6.4.8 Гамшгийн бэлэн байдлыг дэмжих, гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг жендэрийн мэдрэмжтэй олгох;

6.4. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг аймаг, сум, багийн түвшинд хэрэгжүүлэх

6.4.1 Орлого багатай өрхүүдийг аж ахуй эрхлэх бизнесийн сургалтанд хамруулан, сайн дураараа нэгдэн ажиллахад дэмжлэг үзүүлэх, зорилтот бүлгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгож, хадгаламж үүсгэх дадал зуршлыг нэмэгдүүлэх;

6.4.2 Олон хүүхэдтэй бага орлоготой, өрх толгойлсон эцэг эх, ХБИ-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

6.4.3 Жендэрт тулгуурлан зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөтөлбөрт хамруулах;

6.4.4 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр сургалт, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлэх;

6.4.5 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд жендер, зохистой хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлаар сургалт зохион байгуулах;

6.4.6 Уул уурхай, барилга, газар тариалангийн чиглэлээр хөдөлмөр эрхэлж буй иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх;

6.5. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

6.5.1 Боловсролын байгууллагууд уламжлалт ёс заншил, охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх мэдлэг олгох;

6.5.2 Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын талаар зорилтот бүлгийн эцэг эх, гэр бүлийн гишүүдэд сургалт зохион байгуулах, хүүхдийн эрхийн зөрчил, бүх төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх тал дээр холбогдох газар, хэлтсүүдтэй хамтран ажиллах;

6.5.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч болон хүүхдүүдэд сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх “Гэр бүлд зөвлөгөө өгөх” төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

6.5.3. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүд, гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг чадваржуулах;

6.5.4. Уламжлалт ёс заншлыг орчин үеийн залуу гэр бүлүүдийн соёлд нэвтрүүлэх, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх;

6.5.5. Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, бусад арга хэмжээг зохион байгуулж, архинд донтсон иргэдийн судалгааг гарган тохирсон төслийг хэрэгжүүлэх.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ

7.1.1 Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт өөрчлөгдсөн байна.

7.1.2 Төрийн байгууллагуудын жендэрийн асуудлаарх бодлого боловсруулах, төлөвлөх, үнэлэх чадавхи сайжирч, байгууллагын удирдах ажилтнууд жендэрийн сургалтанд хамрагдсан байна.

7.1.3 Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байр /түр хамгаалах байр/-ны үйл ажиллагааг чадваржуулсан байна.

7.1.4 Төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлж, оролцоог хангана.

7.2 Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017)	Зорилто т түвшин (2019)	Зорилто т түвшин (2021)	Хэрэгжүүлэх байгууллагууд
---	------------------	-------------	---------------------	-------------------------	-------------------------	---------------------------

1	Жендэрийн асуудлаарх сургагч багш бэлтгэгдсэн тоо	Тоо	-	20	26	Төрийн болон төрийн бус байгууллагууд
2	Хөдөлмөрийн дотоод журамдаа хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамт, хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг тусгасан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	Хувь	-	Нийт төрийн байгууллага 100%	ААНБ 35%	Төрийн байгууллага ААНБ
3	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет байгуулах	Тоо	1	1	2	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг
4	Ажилгүй иргэдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Хувь	55,3	55,0	54,0	ХХҮГ
5	Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутаг дахь төрийн бус байгууллагаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо	Тоо	-	1	1	Аймгийн ЗДТГ, Жендэрийн салбар хороо ТББ
6	Хоршоололд хамрагдсан эрэгтэйчүүдийн тоо	Хувь	20	40	50	ХААГ
7	Жендэрийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан тушаалтан	Хувь	6.1	50	100	Жендэрийн салбар хороо, сургагч багш нар

Найм. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

Дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх талаар Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Хүний хөгжил" аймгийн дэд хөтөлбөрт оруулсан.

8.1 Улсын болон орон нутгийн төсвөөс тухайн жилд хуваарилсан төсөв

8.2 Олон улсын байгууллага болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

8.3 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусламж

8.4 Бусад эх үүсвэрээс

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

9.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийн явцыг тайлагнах, санал оруулах үүргийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Аймгийн салбар хороо хариуцан гүйцэтгэнэ.

9.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчих, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлээр

олон нийтийг соён гэгээрүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллахыг орон нутгийн төрийн байгууллагууд хариуцан гүйцэтгэнэ.

9.3 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар шаардагдах зардлыг төсөвт тусгана.

9.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвх санаачилгыг дэмжих, орон нутгийн хэвлэл мэдээллээр сурталчилах ажлыг аймгийн Мэдээлэл технологийн алба хариуцна.

9.5. Салбар хороо нь дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг бүтэн жилээр гаргана

9.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнахыг аймгийн Салбар хороо хариуцна.

Арав. Дэд хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээ

10.1. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг АЗДТГ-ын ХШҮДАХ-ээс жил тутам хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

10.2. Дэд хөтөлбөр хэрэгжих хугацаанд хөндлөнгийн үнэлгээг Төрийн бус байгууллагаар 1 удаа хийлгэх ажлыг аймгийн Жендэрийн салбар хороо тухайн жилийн үйл ажиллагаандаа төлөвлөнө.